



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 17 өдөр

Дугаар А/33

Мөрөн

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "а", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтууд, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 43 дугаар тогтоол, Сангийн Сайдын 2014 оны 212 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цагаан-Үүр сумын ерөнхий боловсролын сургуулийн захирлын 2017 оны 15/89 дүгээр албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу тус сургуульд улсын төсвийн урсгал зардлын хөрөнгөөр 23,815,400 (Хорин гурван сая найман зуун арван таван мянга дөрвөн зуун) төгрөгийн төсөвт өртөг бүхий үдийн цай нийлүүлэх гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороог нэгдүгээр, 34,623,600 (Гучин дөрвөн сая зургаан зуун хорин гурван мянга зургаан зуун) төгрөгийн төсөвт өртөгтэй хоол, хүнсний материал нийлүүлэх гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороог хоёрдугаар, 45,000,000 (Дөчин таван сая) төгрөгийн төсөвт өртөгтэй түлш, халаалтын материал нийлүүлэх гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Худалдан авах ажиллагааг хууль тогтоомж, батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Б.Болд)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цагаан-Үүр сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал (А.Раднаабазар)-д үүрэг болгосугай.


ДАРГА



Л.ГАНБОЛД

0110059 d/zahiramj

Аймгийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр
сарын 17-ны өдрийн А/33 дугаар
захирамжийн 01 дүгээр хавсралт



ЦАГААН-ҮҮР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД
ҮДИЙН ЦАЙ НИЙЛҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭГЧ СОНГОХ
ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН
(Төсөвт өртөг-23,815,400 төгрөг)

Үнэлгээний хорооны дарга: Б.Болд-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга


Гишүүд: А.Үүрийнцолмон-Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын хүнсний эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч

Д.Төмөр-"Хоймор нутгийн чулуу" ХХК-ийн нягтлан бодогч

У.Ариунаа-"Хөвсгөл Ус суваг" ХХК-ийн инженер

Нарийн бичгийн дарга: А.Цэрэндулам-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр
сарын 17-ны өдрийн А/33 дугаар
захирамжийн 02 дугаар хавсралт



ЦАГААН-ҮҮР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛЬД ХООЛ, ХҮНСНИЙ МАТЕРИАЛ
НИЙЛҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭГЧ СОНГОХ
ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН
(Төсөвт өртөг-34,623,600 төгрөг)

Үнэлгээний хорооны дарга: Б.Болд-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга


Гишүүд: А.Үүрийнцолмон-Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын хүнсний эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч

Д.Төмөр-"Хоймор нутгийн чулуу" ХХК-ийн нягтлан бодогч

У.Ариунаа-"Хөвсгөл Ус суваг" ХХК-ийн инженер

Нарийн бичгийн дарга: А.Цэрэндулам-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр
сарын 17 ны өдрийн А/33 дугаар
захирамжийн 03 дугаар хавсралт



ЦАГААН-ҮҮР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД
ТҮЛШ ХАЛААЛТЫН МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭГЧ
СОНГОХ ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН
(Төсөвт өртөг-45,000,000 төгрөг)

Үнэлгээний хорооны дарга: Б.Болд-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга

Гишүүд: А.Үүрийнцолмон-Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын хүнсний эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч

Д.Төмөр-"Хоймор нутгийн чулуу" ХХК-ийн нягтлан бодогч

У.Ариунаа-"Хөвсгөл Ус суваг" ХХК-ийн инженер

Нарийн бичгийн дарга: А.Цэрэндулам-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны хэлтсийн дарга